



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит
үйлдвэрийн газрын 2019 оны үйл ажиллагаа,
эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин
болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Б.Гүрсоронзонтой байгуулсан 2019 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзонтой контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

